

Кирилл бичгийн зөв бичих дүрмийг
хялбарчлан заах асуудалд

*Хулангийн ЛХАГВАБАЯР**

Монгол Улс, Улаанбаатар хот, “Монгол Коосэн” Технологийн коллеж,
Ерөнхий эрдмийн тэнхим

Received: 20 August 2025 / **Accepted:** 26 September 2025 / **Published:** 30 December 2025

Хураангуй: Хэлний хэрэглээний явцад хэл шинжлэлд судлуудтай зарим асуудал урган гардаг. Тэр дундаа хэл бичгийг сурч, хэрэглэх явцад тухайн хэлний дүрэм, заах арга зүй, суралцагчийн сурах нийтлэг хэв маяг, цаг үеийн өөрчлөлтөөс үүдэн, шийдвэрлэх шаардлагатай олон асуудал бий болж байдаг. Тухайлбал, орчин үед мэдлэг мэдээллийг хялбарчлан түгээх чиг хандлага хөгжсөөр байна. Жишээ нь: түүх, нийгэм, уран зохиолын ном сурах бичиг, кино контентьг зураг хэлбэрээр бүтээж, тэдгээрийн нийгмийн эрэлт хэрэгцээ ч ихэссээр байна. Хэлний дүрэм, заах арга зүйг ч мөн хялбарчлах, загварчлах шаардлага байна. Бид судалгааны ажилдаа МКТК-ийн монгол хэлний элсэлтийн шалгалтад оролцогчдын 114 эсээ, мөн 2024-2025 оны хичээлийн жилийн 1-р курсийн оюутнуудын бичсэн 74 эсээ, – нийт 188 эсээнд хийсэн шинжилгээнийхээ дүнд гурван хэсэг бүхий судалгааны өгүүлэл бичив. Үүнд: 1. 2024-2025 оны МКТК-ийн 1-р курсийн оюутнуудаас авсан түвшин тогтоох тандалт судалгаа; 2. Кирилл бичгийн зөв бичих дүрмийг хялбарчлан заах арга зүй; 3. 2024-2025 оны хичээлийн жилийн 1-р курсийн монгол хэлний хичээлийн эх бичвэрт хийсэн дүн шинжилгээ. Бид судалгааны ажлаа холбогдох эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан, онол арга зүйн үндэслэлийг гаргаж, хам цагийн үүднээс байдлыг тодорхойлох арга хэрэглэн, судлаачийн зүгээс асуудлыг илрүүлж, шийдэх гарцыг дэвшүүлэхээр зорив.

Түлхүүр үгс: Зөв бичих дүрэм, заах арга зүй, уламжлал, шинэчлэл

Teaching of Orthography in Cyrillic Letter
in a Simple Way

LKHAGVABAYAR Khulan

Department of General Studies, “Mongol Kosen” College of Technology,
Ulaanbaatar, Mongolia

* © Х. Лхагвабаяр, 2025, Email: Lkhagvabayar.kh@mk.edu.mm



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license.

Abstract: Linguistic issues naturally arise in the course of language use. In particular, as people learn and utilize language and writing systems, a variety of problems emerge due to grammatical rules, teaching methodologies, learners' common learning patterns, and contemporary changes. For example, there is an increasing trend toward simplifying the dissemination of knowledge and information. Topics such as history, society, and literature are increasingly presented through visual forms like books, documentaries, and other content, reflecting social demand and needs. Therefore, there is a need to simplify and model language rules and teaching methods accordingly. For this research, materials from 103 essays from the Mongolian Language entrance exam of the Mongol Kosen College of Technology (MKCT) and 74 essays from first-year students of the 2024-2025 academic year were used. The study consists of three parts: 1. A survey assessing the language proficiency level of first-year students in the 2024-2025 MKCT; 2. Methods to simplify the Cyrillic script spelling rules; 3. An analysis of first-grade MKCT textbooks for the 2024-2025 academic year. Based on relevant primary sources, a study aims to establish theoretical and methodological foundations, determine the current situation from a comprehensive perspective, identify issues, and propose potential solutions.

Key words: Orthography, Teaching Methodology, Tradition and Innovation.

1. Удиртгал

Хэл бичгийн дүрмийг хялбарчлах аргыг уламжлалт заах арга зүйд ч хэрэглэж байсан, одоо ч хэрэглэсээр байна. Тухайлбал, монгол бичигт зөөлөн дэвсгэр гийгүүлэгчийг “Манланг - м, н, л, нг”, хатуу дэвсгэр гийгүүлэгчийг “Багарсад – б, г, р, с, д”; “Холбох эгшгийн дүрэм”-ээр хувилгагч буюу гэдэс залгаж бичдэг гийгүүлэгчийг “Яган молор – я, г, н, м, л, р”, эс хувилгагч буюу гэдэс жийрэглэхгүй шууд залгаж бичдэг гийгүүлэгчийг “Жич бусад хот – ж, ч, б, с, д, х, т”; кирилл бичигт эгшигт гийгүүлэгчийг “Монгол баавар – м, н, г, л, б, в, р”, заримдаг гийгүүлэгчийг “Цоожоо засаад тушаачих – ц, ж, з, с, д, т, ш, ч, х” гэх мэт зохиомол үгээр цээжлүүлж заадаг арга зүй бий. Иймэрхүү заах арга зүйг цаашид улам боловсронгуй болгож, сургалтдаа ашиглах шаардлага байсаар байна.

Монгол хэлний зөв бичих дүрмийг боловсронгуй болгох, нийтэд түгээн дэлгэрүүлэх талаар төрөөс шат дараатай хэд хэдэн ажил хийсний нэг нь “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь” (2018) бичгийг Ерөнхийлөгчийн дэргэдэх ХБЗ-өөс эрхлэн, ШУА-ийн ХЗХ, МУИС, МУБИС-ийн эрдэмтэд хамтран бүтээсэн билээ. Уг толь бичгийг 1983 оны Ц.Дамдинсүрэн, Б.Осор нарын “Монгол хэлний үсгийн дүрмийн толь” (1983) бичигт тулгуурлан гаргажээ. Мөн 2011 онд “Монгол хэлний зөв бичих дүрмийг боловсронгуй болгох мэргэжлийн зөвлөгөөн”, 2016 онд “Эх хэлний цахим хөгжил-2016” чуулган, 2020 онд “Монгол хэл бичгийн асуудал, шийдэл” үндэсний чуулган зэрэг мэргэжлийн эрдэмтэн судлаачдыг хамруулсан чуулган тус тус болжээ.

Хууль эрх зүйн талаас гэвэл,

Монгол Улсын Их Хурлаас баталсан дээрх ажлуудын үр дүнд тулгуурлан, Засгийн газраас боловсролын салбарт 1997–2005 онд хийх өөрчлөлтийн үндсэн чиглэл (1997), Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-1, Бүх нийтэд суурь боловсрол эзэмшүүлэх үндэсний хөтөлбөр (1995), Англи хэлний сургалтын чанарыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2001) зэрэг бодлогын баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлж байна. Түүнчлэн Боловсролын багц хууль (1995, 1998, 2002, 2006, 2008), Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль (2008), Монгол Улсын Боловсролыг 2006–2015 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө (2006), Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр (2004) зэрэг ажлыг хэрэгжүүлжээ (Гэрэлмаа нар, 2020: 633). Мөн 2015 онд “Монгол хэлний тухай хууль”-ийг баталсан юм.

Гэхдээ Кирилл бичгийн зөв бичих дүрмийн заах арга зүйг боловсронгуй болгох талаар хөндөж, хэлэлцүүлсэн нь тун ховор байна. Зөв бичих дүрмийг сайжруулах талаар Ц.Дамдинсүрэн “Үсгээ өөрчлөхгүй дүрмээ сайжруулъя” (1957), “Монгол хэл бичгийн зарим асуудал” (1959), Ш.Барайшир “Үсэг бичгээ улам сайн болгохын төлөө” (1959), Д.Төмөртоогоо “Кирилл үсгийн зөв бичих дүрмийг засан сайжруулах шаардлага” (2009), Ц.Оюун “Зөв бичих

дүрмийн бүтэц тогтолцоо ба шинэчлэл” (2017), Г.Батзаяа “Кирилл, монгол бичгийн зөв бичих дүрмийн харьцуулал” (2009), Б.Мөнгөнцэцэг “Орчин цагийн монгол хэлний зөв бичих дүрмийн зарим асуудалд” (2017) зэрэг эрдэм шинжилгээний өгүүллүүд нийтлүүлжээ. Мөн 1975, 2003, 2013 онуудад нэр бүхий эрдэмтэд үг зүйн зарчмыг голлон баримталсан зөв бичих дүрмийг сайжруулах төсөл боловсруулж байсан. Мөн Д.Батцогт, Г.Батзаяа нар “Кирилл монгол бичиг” (2009) ном бичиж кирилл үсгийн дүрмийг өөрчлөн сайжруулах төсөл боловсруулжээ. Энэ мэтчилэн бусад эрдэмтдийн бүтээлүүд ч байдаг.

Кирилл бичгийн зөв бичих дүрмийн толь бичгүүд:

1. Ц.Дамдинсүрэн, Я.Цэвэл, “Үсгийн дүрмийн зөв бичих толь” (1951)
2. С.Мөөмөө, “Зөв бичих дүрмийн толь” (1962)
3. Х.Далхжав, Ц.Цэрэнчимэд “Зөв бичих зүйн толь бичиг” (1974)
4. Ц.Дамдинсүрэн, Б.Осор, “Монгол хэлний үсгийн дүрмийн толь” (1983)
5. Б.Мөнхцэцэг “Орчин цагийн монгол хэлний зөв бичих толь” (2016)
6. Хэлний Бодлогын Үндэсний Зөвлөл. “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь” (2018) эдгээр толь бичиг хэвлэгджээ.

Энэ мэтчилэн төрөөс болон эрдэмтэн судлаачдын зүгээс зөв бичих дүрмийг боловсронгуй болгох талаар хийж хэрэгжүүлж буй ажлууд цөөнгүй ч нэгдсэн бодлоготойгоор дорвитой өөрчлөлт хийсэн зүйлгүй, ард иргэдийн хэл бичгийн хэрэглээний түвшин хангалтгүй, чадвар доогуур, шүүмжлэл, бухимдал их байсаар байна.

Тухайлбал, Г.Гэрэлмаа, Дарьяа Бадмаевна Гедеева нарын “Монгол хүний бичиг үсгийн чадварын судалгаа”(2020) (албан ёсны кирилл үсгийн жишээн дээр) сэдэвт нийгэм хэл шинжлэлийн судалгаанд 18-30, 31-40, 41-60 насны багш, тогооч, үсчин, оюутан, жолооч, эдийн засагч, бизнесийн удирдлага, орчуулагч зэрэг 10 гаруй мэргэжлийн 58 хүнийг хамруулж кирилл бичгийн чадварыг шалгахдаа “зөв бичгийн дүрмийн сорил”, “ажилд орох өргөдөл бичих сорил” тус тус авчээ. Судалгаагаар нийт чадварын түвшин 50%-иас доогуур гарсан бөгөөд, ялангуяа эхний бүлэг 18–30 насны 23 хүн (бүрэн дунд боловсролтой нь 6, дээд боловсролтой нь 17)-ий кирилл бичгийн чадварын түвшин 47,5%, хамгийн дээд чадвартай нь сорилын 60 орчим хувийг гүйцэтгэсэн байна. Тэд кирилл үсгээр бичихдээ латин үсэг холих (t, d гэх мэт), мөн гээгдэх эгшгийн дүрмийг мэдэхгүйгээс алдах тохиолдол их, бичгийн хэлбэр сайнгүй гаргацтай муутай бичсэн байх нь түгээмэл байв (2020: 628-629). Мөн хууль тогтоомжийн бичвэр дэх алдааны судалгаагаар 2007-2017 онд Монгол Улсын Их Хурлаас баталсан 220 орчим хуулийн үгийн санд 481 үг зөв бичих дүрмийн алдаатай байсан нь тогтоогджээ.

Эдгээр судалгааны дүнгээс кирилл бичгийн зөв бичих дүрмийн ойлголт, эзэмших чадварыг хэрэглээний түвшинд сайжруулах зайлшгүй шаардлага харагдаж байна.

АНУ, Нидерланд, Их Британи, Калифорния (АНУ-ын муж), Испани зэрэг улс орны боловсрол эзэмшүүлэх уламжлалд explicit spelling instruction (тодорхой зөв бичих чадвар), SWI-Structured Word Inquiry (үгийн бүтцэд тулгуурласан арга зүй), multisensory (мэдрэхүйн ялгаатай байдалд тулгуурласан арга зүй), error based (алдаан дээр тулгуурласан арга зүй), word sorts (үгийг ангилан заах) зэрэг бичиг үсэг заах олон арга зүй байдаг. Тухайлбал, Испанийн эрдэмтэн Luz Rello, Clara Bayarri, Yolanda Ota, Martin Pielot нар “A Computer-Based Method to Improve the Spelling of Children with Dyslexia (Дислекс буюу бичгийн дүрмийн чадвар сул хүүхдийг компьютерт суурилсан аргаар сайжруулах нь)” (2015) сэдэвт судалгааны хүрээнд хийсэн ажлаа: “Манай судалгааны баг алдаатай үгийг олж засах дасгал ажлыг компьютерын тусламжтай ажиллуулах дасгал ажил бүтээсэн. Уг дасгалыг гүйцэтгэхдээ зөв бичих чадвар сул хүүхдүүдийн бичвэр дэх алдааг олж, өөрийн хэл шинжлэлийн суурь мэдлэгт тулгуурлан, зөв бичих дүрмээ сайжруулах явдал юм (Luz Rello, Clara Bayarri, Yolanda Ota, Martin Pielot, 2014: 153) хэмээн танилцуулсан байдаг. Дэлхийн бусад оронд ч мөн бичиг үсгийг хялбарчлан заах арга зүйг судалсан туршлага байгаа нь дамжиггүй. Энэ талаар цаашид манай улсын эрдэмтэн судлаачид анхаарлаа хандуулж, гүнзгийрүүлэн судлах, заах арга зүйн дэвшилттэй шинэлэг санаанууд нэвтрүүлэх, цахим орчныг энэ асуудалд тохируулан ашиглах шаардлагатай юм.

2. Судалгааны арга зүй

Бидний энэ удаад өгүүлж буй судалгааны ажлын гол зорилго нь кирилл бичгийн зөв бичих дүрмийг тэмдэгт, томъёо, схемээр хялбарчлах, бүлэглэх аргаар суралцагчдад ойлгуулах арга зүй боловсруулах, цаашид судалгааны эргэлтэд оруулах, хэрэглээнд нэвтрүүлэхэд оршино. Зөв бичих дүрмийг заах арга зүйн дэлгэрэнгүй зөвлөмж нь мэргэжлийн багш, оюутанд ойлгомжтой ч бага, дунд, ахлах ангийн сурагчид, мэргэжлийн бус ангийн оюутнууд болон нийтийн бичгийн боловсролыг сайжруулахын тулд түүний тайлбарыг хялбарчлах шаардлага бий болж байна. Учир нь хэт дэлгэрэнгүй тайлбар нь суралцагчдыг залхаах, уншиж, цээжлэхээс төвөгшөөх, шантрахад хүргэдэг юм. 2024-2025 оны хичээлийн жилийн 1-р курсийн 64 оюутнаас авсан санал асуулгад “Олон дүрэм байдаг учир сурахад төвөгтэй” гэдэг хариултыг 30 оюутан сонгосон байна.

Жил бүрийн монгол хэл бичгийн шалгалтын агуулгад багтдаг нийтлэг дүрмүүд нь:

1. Балархай эгшгийн дүрэм (эгшигт ба заримдаг гийгүүлэгчийн дүрэм)
2. Үг бүтээх ‘-л’ дагаврын дүрэм
3. Үйлт нэрийн ‘-х’-ийн дүрэм
4. Зөөлний тэмдгийн дүрэм
5. Ялгах эгшгийн дүрэм байдаг.

Эндээс бид оюутнуудын хамгийн түгээмэл алдаа гаргадаг “Балархай эгшгийн дүрэм”-ийг бусад дүрэмтэй холбон “Томъёочлон хялбарчлах арга”, мөн бүх дүрмийг бус нийтлэг хэрэглэгддэг дүрмийг “Бүлэглэн ойлгуулах арга” боловсруулан, хичээл сургалтын үйл ажиллагаандаа хэрэглэж байгаа бөгөөд цаашид уг арга зүйг улам сайжруулж, ашиглах боломжтой гэж үзэж байгаа юм.

Аливаа улс үндэстний нэгдмэл байхын нэг чухал үндэс нь нийтээр баримтлах бичгийн хэлний хэм хэмжээ байдаг (Мөнгөнцэцэг, 2017: 69). Тэгвэл бичгийн хэлний хэм хэмжээг зөрчихгүй байх, хэрэглээг боловсронгуй болгох гол үндэс нь зөв бичих дүрмийн заах арга зүйн асуудал юм. Бид энэхүү судалгаагаараа суралцагчдад тулгарч буй асуудлыг илрүүлж, заах арга зүйн хүрээнд шийдвэрлэх арга замыг дэвшүүлэхийг чухалчлав.

3. МКТК-ийн 1-р курсийн оюутнуудаас авсан түвшин тогтоох тандалт судалгаа

3.1. Монгол хэлний элсэлтийн шалгалтын материалд хийсэн дүн шинжилгээ

Бид 2024-2025 оны монгол хэлний элсэлтийн шалгалтад оролцсон 114 сурагчийн материал болон МКТК-д элссэн 74 оюутны хичээл дээр бичсэн эсээнд дүн шинжилгээ хийв.

Хүснэгт 1. Нийт 188 сурагчийн эсээнд хийсэн дүн шинжилгээ (цөөнөөс олон руу эрэмбэлэв.)

Түгээмэл алддаг дүрэмд хийсэн дүн шинжилгээ /тоон үзүүлэлтээр/			
№	Алдсан дүрэм, зарчмууд	Сурагчийн тоо	Алдсан давтамж
1.	Одоо, ирээдүй цагийн ‘-на ⁴ ’ нөхцөлийг бичих дүрэм	7	12
2.	Хам холбох болон хамаатуулах ‘нь’ нөхцөлийг ялган бичих дүрэм	8	20
3.	Чиглэхийн тийн ялгалыг бичих дүрэм	10	13

4.	Туслах эгшиг ‘-я, -ё, -е, -ю’-г бичих дүрэм	13	20
5.	Одоо, ирээдүй цагийн “на ⁴ ”, хам холбох нөхцөлийг ялган бичих дүрэм	16	20
6.	Тусгаарлах эгшгийн дүрэм	19	34
7.	Дуудах сул үг ‘аа’, хамаатуулах ‘-аа’ нөхцөлийг ялган бичих дүрэм	19	21
8.	Зэрэгцүүлэх, холбох нөхцөлийг бичих дүрэм	21	33
9.	Үг бүтээх ‘-л’ дагаврын дүрэм	27	41
10.	Дуудах сул үг ‘л, ч’-г бичих дүрэм	29	40
11.	Эр үгэнд ‘-ий’ бичих дүрэм	31	39
12.	Гадаад үгийг зөв бичих дүрэм	31	68
13.	Уламжлалт бичлэгтэй үгийг бичих дүрэм	39	59
14.	Үйлт нэрийн ‘-х’ нөхцөлийг бичих дүрэм	58	68
15.	Балархай эгшгийг гээх ба гээхгүй бичих дүрэм	72	117

Дүгнэлт:

1. Ярианы найруулгаар бичсэн тохиолдол түгээмэл байна. Жишээ нь: *явцан (явчихсан), энэнийг /энийг (үүнийг), тэрнийг (түүнийг), ороол (ороод л), надыг (намайг)* гэх мэт. Мөн сэтгэл хөдлөлөө илэрхийлэх зорилгоор бичгийн найруулгад ярианы найруулгыг ашиглаж бичих тохиолдол их байна. Жишээ нь: *товчхоон, мэдсээн, ирнээ* гэх мэт.
2. Өгүүлбэр төгсгөх, эхлүүлэх, цэг тэмдэг ашиглаж мэдэхгүй суралцагчид цөөнгүй байна. Догол мөр авах буюу цогцолбороор зааглаж бичих нь тун ховор байна.
3. Журамласан буюу уламжлалт бичлэгтэй үгс, дүрс ялган бичдэг үгсийг нүдлэн тогтоогоогүйн улмаас буруу бичих нь их байна.
4. Ойролцоо дуудлагатай авиаг андуурч бичих нь элбэг. Жишээ нь: ‘э-и’, ‘д-т’, ‘ө-ү’, ‘з-ц’ гэх мэт.
5. Дүрмийн алдааны тоо, давтамжийг эрэмбэлж үзвэл “Балархай эгшгийн дүрэм”, “Үйлт нэрийн ‘-х’ нөхцөлийг бичих дүрэм”-ийг хамгийн их алдаж байна.

3.2. Кирилл бичгийн зөв бичих дүрмийг сурахад суралцагчдад тулгардаг нийтлэг асуудлууд

Хүснэгт 2. Нэгдүгээр курсийн 64 оюутнаас авсан асуулга (цөөнөөс олон руу эрэмбэлэв.)

№	Тулгардаг асуудал	Хариулсан оюутны тоо
1.	Сурах арга барил сайн эзэмшээгүй	9
2.	Сурах цээжлэх сонирхол төрдөггүй	12
3.	Үгийн сангийн баялаг дутмаг	17
4.	Олон дүрэм байдаг учир сурахад хүндрэлтэй	30
5.	Дүрмүүд нарийн төвөгтэй, эргэлзээтэй	43

6.	<u>Бусад</u>: /дээрх 5 асуудлаас гадна нэмэлт тулгарч буй асуудал/ -Цар тахлын үеийн цахим хичээлээс үүдэлтэй хичээлийн хоцрогдол -Бага, дунд ангийн суурь муу байсан -Зөв бичих дүрмээс илүүтэй дагавар, нөхцөлийн учрыг сайн ойлгодоггүй -Өөрөө сайн хичээдэггүй -Балархай эгшгийн дүрмийг сайн мэддэггүй -Ойлгоогүй зүйлээ багшаас асууж чаддаггүй байсан -Бага ангид олон багш солигдож орсноос үүдэн сайн сурч чадаагүй -Хурдан бичихийн тулд хамаагүй бичдэг -Урт үгийг алдаж бичдэг -Буруу сонсож бичдэг -Олон хичээл ордог учир заримдаа дүрмээ давтаж амждаггүй -Дүрэм харахаар уур хүрдэг -Дүрмүүдээ хооронд нь хольж хутгаад байдаг -Сурмаар байдаг ч дүрмийн тайлбар хэтэрхий нуршсан байдаг -Зарим үг монголоор биш, англиар орж ирээд байдаг
----	---

(Дээрх 5 хариултаас суралцагч бүр 1-3-ыг сонгосон.)

Дүгнэлт:

Оюутнуудаас авсан асуулгын дүнгээс ажиглавал, дүрмүүд нарийн төвөгтэй, эргэлзээтэй байдаг, олон дүрэм байдаг учир сурахад хүндрэлтэй байдаг гэж хамгийн олон оюутан хариулсан нь бидний судалгааны ажлын үндэслэлтэй нийцэж байна.

Мөн асуулгын “Бусад” хэсэгт: “Балархай эгшгийн дүрэм”-ийг мэддэггүй, дүрэм харахаар уур хүрдэг, дүрмүүдээ хооронд нь хольж хутгаад байдаг, сурмаар байдаг ч дүрмийн тайлбар хэт нуршсан гэх мэт санал бичсэн нь энэ шаардлагыг давхар баталж байна. Судалгааны дүнгээс кирилл бичгийн зөв бичих дүрмийг хялбарчлах, заах арга боловсронгуй болгох зайлшгүй шаардлага харагдаж байна.

4. Кирилл бичгийн зөв бичих дүрмийг хялбарчлан заах арга зүй

Бид энэхүү хэсэгтээ сурагчдын нийтлэг алддаг 10 дүрмийг хялбарчлан ойлгуулах боломж байгааг харуулахыг зорьж, “Томьёочлон хялбарчлах арга”, “Схемчлэх арга”, “Тэмдэгтээр хялбарчлах арга” хэмээх гурван арга зүйг боловсруулснаа танилцуулна.

4.1. Балархай эгшгийн дүрмийг хялбарчлан заах боломж

Хүснэгт 3. “Томьёочлон хялбарчлах арга”

№	Балархай эгшгийн томьёо	Жишээ үг
1.	7+7=7Э7, 77Э	гарал, загвар, самбар (гарлын, загвараар, самбараас)
2.	9+7=97Э	дасгал, дуртгал, үрчгэр (дасгалаар, дуртгалын, үрчгэрийг)
3.	7+9=79	галч, хөрс, номт (галчдыг, хөрсний, номтноос)
4.	9+9=9Э9, 99Э /сх+тч/	малчид, курст (малчдын, төрөлхтний)
5.	7ь+7=7и7	барь, хорь, зорь (барилаа, хоригоор, зорилоо)
6.	9ь+7=9и7	сахь (сахив, сахилыг, сахина)
7.	9ь+9=9и9	тахь (тахижээ, тахиж, тахидаг)
8.	7ь+9=7ь9	барь, сорь, халь (барьцны, сорьжээ, хальсаар)

Хялбарчлал нь:

1. Эгшигт гийгүүлэгч(7)-ийг өмнө нь юм уу хойно нь заавал эгшигтэй бичнэ.
2. Заримдаг гийгүүлэгч(9)-ийг эгшигт гийгүүлэгчийн дараа эгшиггүй, заримдаг гийгүүлэгчийн дараа эгшигтэй бичнэ. Жич: *сх+тч* дараалан ороход эгшиггүй бичнэ.
3. Зөөлний тэмдэг эгшигт+эгшиг, заримдаг+эгшигт, заримдаг+заримдаг гийгүүлэгчийн дунд орвол ‘и’ эгшиг болж хувирдаг, харин эгшигт+заримдаг гийгүүлэгчийн дунд байвал хувирдаггүй.

гэсэн дүрмүүдийг тус тус хялбарчлан, нэг цогц томъёогоор ойлгуулах боломжтой.

Схем 1. “Схемээр хялбарчлах арга”

Балархай эгшгийн үүрэг

Эгшигжүүлэх – 7/9 эгшигжүүлэх үүрэггүй бол гээнэ, үүрэгтэй бол гээхгүй.

Ялгах – Оноосон нэр, га/го # г, на/нэ/но/нө # н, үйлт нэр ‘-х’ гээхгүй.

Зөөлрүүлэх – Эр үгэнд ‘ж’, ‘ч’, ‘ш’-ээс бусад гийгүүлэгчийн дараах зөөлрүүлэх үүрэгтэй ‘и’ гээхгүй.

Хялбарчлал нь:

Балархай эгшгийг ямар үед гээдэг, ямар үед огт гээдэггүй тохиолдлыг схемчлэн ойлгуулж, харааны ойд хоногшуулах боломжтой.

4.2. /я, е, ё/ нөхцөлийг бичих дүрмийг хялбарчлах нь

Хүснэгт 4. “Тэмдэгтээр хялбарчлах арга”

№	Үйл үгийн төгсгөл + я, е, ё	Жишээ үг
1.	ь/Э - [+шууд залгах/тохирох авиа]	барья, зорье, уулгая, болгоё, зүлгее, өргөө
2.	я, е, ё - [+ижил авиаг шууд залгах]	уая, оёё, хаяя
3.	Г - [эр эгшигтэй үг+ь/тохирох авиа]	уриалья, олье, харья, тосье
4.	Г- [эм эгшигтэй үг+ь/тохирох авиа]	хүсье, төлье, хэлье
5.	Тус дүрэмд нэр үгсийг хольж болохгүй	авьяас, гавьяа, харьяа, завьяа, томьёо, товьёг

Хялбарчлал нь:

‘я, е, ё’ нөхцөл залгахад үгийн үндсээс хэрхэн тусгаарладаг дүрмийг хураангуйлан ойлгуулах боломжтой. Мөн ‘ь,ъ’-ийн дүрмийн хэрэглээний ялгаатай тохиолдлыг давхар тайлбарлах боломжтой юм.

4.3. -ы/-ий эгшгийг эгшиг, гийгүүлэгчтэй зохицуулан залгах дүрмийг хялбарчлах нь

Хүснэгт 5. “Тэмдэгтээр хялбарчлах арга”

№	Хялбарчлах дүрэм	Жишээ үг
1.	Ж, Ч, Ш [-ий]	баг <u>ш</u> ийн, хай <u>ч</u> ийг, цоо <u>ж</u> ийг
2.	Г (хэлний үзүүрийн) [-ий]	ов <u>г</u> ийн, бул <u>г</u> ийг, ба <u>г</u> ийн
3.	Б [ө-ий]	сургууль-сургуулийн, модуль-модулийн, завь-завийг
4.	И [ө-ий]	анги-ангийн, тамхи-тамхийг, биологи-ийн, лаборатори-ийн, геологи-ийн
5.	БУСАД эр үг (а,о,у) [-ы]	хаваржааны, боловсролын, агуулга-агуулгыг
6.	БУСАД эм үг (э,ө,ү) [-ий]	үндэслэлийг, мэргэжлийн, эмнэлгийг

Хялбарчлал нь:

Эр эгшигтэй үгэнд ‘-ы’, эм эгшигтэй үгэнд ‘-ий’ эгшиг бичдэг ерөнхий дүрэм болон тусгай тохиолдолд эгшиг, гийгүүлэгчтэй зохицуулж эр эгшигтэй үгэнд -ий эгшиг бичдэг дүрмийг цогцоор ойлгуулж болно.

4.4. Үг бүтээх ‘-л’ дагавар болон одоо, ирээдүй цагийн ‘-на⁴’ нөхцөлийг хялбарчлах нь

Хүснэгт 6. “Томьёочлон хялбарчлах арга”

№	‘-л’ дагавар	Жишээ үг
1.	7+л=7лЭ	ном <u>л</u> о, журам <u>л</u> а, ажил <u>л</u> а, бор <u>л</u> о
2.	9+л=9Эл	бу <u>т</u> ал, за <u>д</u> ал, за <u>х</u> ал, дээ <u>ж</u> ил
3.	Ж, Ч, Ш+л=Ж, Ч, Ш ‘И’л	цоо <u>ж</u> ил, хай <u>ч</u> ил, баг <u>ш</u> ил, хоч <u>ил</u>
4.	9Эс+л=9ЭслЭ	хав <u>т</u> асла, хув <u>ц</u> асла, эц <u>э</u> слэ, үнд <u>э</u> слэ /2 заримдаг гийгүүлэгч/
№	‘-на ⁴ ’ нөхцөл	Жишээ үг
1.	7+(-на ⁴)=7(-на ⁴)Э	хар <u>н</u> а, ол <u>н</u> о, хэл <u>н</u> э /1 гийгүүлэгч + шууд залгана/
2.	9+(-на ⁴)=с(-на ⁴)	бос <u>н</u> о, нис <u>н</u> э, хүс <u>н</u> э, дас <u>н</u> а /1 гийгүүлэгч + шууд залгана/
3.	99+(-на ⁴)=99Э(-на ⁴)	баг <u>т</u> ана, ал <u>х</u> ана, олдо <u>н</u> о /дараалсан 2 гийгүүлэгч Э авна/

Хялбарчлал нь:

‘-л’, дагавар, ‘-на⁴’ нөхцөлийг нэг ба хоёр эгшигт ба заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд залгахад эгшигжүүлэх үүрэгтэй балархай эгшиг тухайн дагавар, нөхцөлийн хаана байрлахыг хялбар томьёогоор ойлгуулах боломжтой.

5. 2024-2025 оны хичээлийн 1-р курсийн монгол хэлний хичээлийн эх бичвэрт хийсэн дүн шинжилгээ

МКТК-ийн монгол хэлний элсэлтийн шалгалтын материал, 2024-2025 оны хичээлийн явц дахь бичвэрүүдийг харьцуулан шинжлэв.

Хүснэгт 7. Элсэлтийн шалгалт болон хичээл дээр бичсэн эсээний зөв бичих дүрмийн алдааны харьцуулалт (Алдаа цөөрсөн байдлыг багаас их рүү эрэмбэлэв.)

Харьцуулсан бичвэрийн тоон үзүүлэлт				
№	Алдсан дүрэм, зарчмууд	ЭЕШ /114 сурагчийн материал/ 2024.06.08	Хичээлийн явц /74 эсээ/ 2025. 03.28	Алдаа цөөрсөн байдал
1.	Чиглэхийн тийн ялгалыг бичих дүрэм	10	-	0
2.	Туслах эгшиг 'я, ё, е, ю'-г бичих зарчим	13	-	0
3.	Одоо, ирээдүй цагийн '-на ⁴ ' нөхцөлийг бичих дүрэм	7	2	-5
4.	Хам холбох ба хамаатуулах 'нь' нөхцөлийг ялган бичих зарчим	8	3	-5
5.	Одоо, ирээдүй цагийн '-на ⁴ ' ба - хам '-н' нөхцөлийг ялган бичих зарчим	16	6	-10
6.	Үг бүтээх '-л' дагаврын дүрэм	27	16	-11
7.	Дуудах сул үг 'аа' ба хамаатуулах 'аа' нөхцөлийг ялган бичих зарчим	19	6	-13
8.	Үйлийн '-ж, -ч' нөхцөлийг бичих дүрэм	21	8	-13
9.	'-я,-е, -ё' нөхцөлийг зөв бичих дүрэм	19	3	-16
10.	Дүрсээр утга ялгахар журамласан үгийг бичих дүрэм	39	22	-17
11.	Дуудах сул үг 'л, ч'-г бичих дүрэм	29	10	-19
12.	Гадаад үгийг зөв бичих дүрэм	31	12	-19
13.	Үйлт нэрийн '-х'-г бичих дүрэм	58	39	-19
14.	Балархай эгшгийн дүрэм	72	53	-19
15.	Эр үгэнд '-ий' бичих дүрэм	31	10	-21

Дүгнэлт:

Ийнхүү бид МКТК-д элссэн оюутнуудад тус өгүүлэлд танилцуулж буй өөрсдийн боловсруулсан хялбарчлан заах аргуудаар хичээл заасны дүнд ЭЕШ-д түгээмэл алдаж байсан 15 дүрмийн алдаа 0-21 тохиолдлоор цөөрсөн үр дүнтэй байв. Ялангуяа “Балархай эгшгийн дүрэм”, “Үйлт нэрийн '-х'-ийн дүрэм”-ийг алдаж буй тохиолдол нь бусад дүрэмтэй харьцуулахад өндөр байгаа ч тус бүр 19-өөр цөөрсөн байна. Цаашид уг судалгааны туршилтыг удаан хугацаанд хэрэгжүүлж, үр дүнгийн үзүүлэлтийг гаргахдаа 1-3 р курстэй нь харьцуулах, судалгааны материал, эсээг ижил сэдвээр бичүүлж, дүн шинжилгээ хийвэл хэмжилт илүү тодорхой болж, өсөлт, бууралтыг гаргах боломжтой юм.

6. Судалгааны үр дүн

6.1. Бид 2024-2025 оны хичээлийн жилийн монгол хэлний элсэлтийн шалгалтын 114 сурагчийн материал, хичээл дээр бичсэн 74 оюутны эсээнд дүн шинжилгээ хийхэд 15 дүрмийг нийтлэг алдаж байсан бөгөөд тус дүрмийг алдсан сурагчийн тоо / алдааны давтамжийг нь тодорхойлбол, “Балархай эгшгийн дүрэм”-ийг 72/117, “Үйлт нэрийн –х” бичих дүрмийг 58/68, “Уламжлалт бичлэгтэй үг”-ийг 39/59, “Гадаад үгийг зөв бичих дүрэм”-ийг 31/68, бусад дүрэм 7-31/12-39 гэсэн үзүүлэлт гарч байна. Уг үзүүлэлт нь кирилл бичгийн зөв бичих дүрмийг, эсвэл заах арга зүйг сайжруулах зайлшгүй шаардлагыг илтгэж байна (*Хүснэгт 7*).

6.2. Монгол хэлний зөв бичих дүрмийг сайжруулах талаар төрөөс болон салбарын эрдэмтдийн зүгээс хийж хэрэгжүүлсэн ажил цөөнгүй ч түүнийг заах арга зүйн асуудлын талаар хийж хэрэгжүүлсэн ажил тун ховор байна. Тиймээс энэ асуудлыг хэрэглээний түвшинд сайжруулахын тулд заах арга зүйг улам боловсронгуй болгох шаардлагатай байна.

6.3. Бид кирилл бичгээр бичигчдийн хамгийн нийтлэг алддаг дүрэм болох “Балархай эгшгийн дүрэм”, “Эгшигт гийгүүлэгчийн дүрэм”, “Заримдаг гийгүүлэгчийн дүрэм”, “Зөөлний тэмдэг хувирах, эсэх дүрэм”, “с,х-ийн дараах т,ч гийгүүлэгчийн дүрэм” зэрэг 5-6 дүрмийг “Томьёочлон хялбарчлах арга”-аар ойлгуулах боломжийг дэвшүүлэв (*Хүснэгт 3, Схем 1*). “Балархай эгшгийн үүрэг”-ийг тодорхойлж, балархай эгшиг гээгдэх, гээгдэхгүй тохиолдлыг заах аргын талаас нь схемчлэн хялбарчлах аргаар гаргав (*Схем 1*). “Тусгаарлах эгшгийн дүрэм”-ийг “Тэмдэгтээр хялбарчлах арга”-аар, ‘-я, -е, -ё’ нөхцөлийг үгийн үндсээс хэрхэн тусгаарладаг, мөн нэр үгэнд ямар ч тохиолдолд ‘ь’ тэмдэг бичдэг болохыг давхар ойлгуулах боломжтой юм. Мөн “-ы/-ий эгшгийг эгшиг, гийгүүлэгчтэй зохицуулан залгах дүрэм”-ийг “Тэмдэгтээр хялбарчлах арга”-аар (*Хүснэгт 5*.) ба “Үг бүтээх ‘-л’ дагавар” болон “Одоо, ирээдүй цагийн ‘-на’” нөхцөлийг залгах дүрэм”-ийг “Томьёочлон хялбарчлах арга”-аар (*Хүснэгт 6*.) тус тус дөхөмчлөн заах боломж байна.

6.4. Бид жил бүрийн МКТК-д элсэгчдийн монгол хэлний шалгалтын материал дахь алдаанд хийсэн дүн шинжилгээндээ үндэслэн, 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн шат дараатайгаар кирилл бичгийн зөв бичих дүрмийг хялбарчлан заах аргыг боловсруулж, хичээл сургалтдаа ашиглаж ирсэн бөгөөд уг аргаар 1-3-р курс хүртэл заахад мэдэгдэхүйц ахиц гарч, үр дүн нь тухайн хичээлийн жилийн улирлын болон жилийн эцсийн амжилт, чанарын үзүүлэлтээс тодорхой харагдав. Иймд 2024-2025 оны хичээлийн жилийн элсэгчдийн материалд дүн шинжилгээ хийж, зөв бичих дүрмийн мэдлэгийг сайжруулах арга зүйг амьдрал практикт нэвтрүүлэх, судалгааны эргэлтэд оруулах зорилгоор томьёочлон хялбарчлах, тэмдэгтээр хялбарчлах, схемээр хялбарчлах зэрэг аргыг дэвшүүлж байна. Боломжит үр дүнд хүрэхийн тулд тодорхой хугацаа шаардлагатай байдаг учир энэ жилийн 1-р курсийн оюутнуудын кирилл бичгийн зөв бичих дүрмийн мэдлэг тус хичээлийн жилийн 2, 3-р курсийн оюутнуудын адил мэдэгдэхүйц сайжрах боломж байгаа гэж үзэж байна.

7. Дүгнэлт

Дээр танилцуулсан арга зүйгээр кирилл бичгийн зөв бичих дүрмийг заасны үр дүнд МКТК-ийн оюутнуудын монгол хэлний хичээлийн 2021-2025 оны хоорондох нийт 4 хичээлийн жилийн амжилт, чанар ахисан байдлыг графикаар үзүүлбэл:




График 1. МКТК-ийн оюутнуудын монгол хэлний хичээлийн жилийн эцсийн дүнгийн амжилт, чанарын ахиц

Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 8. МКТК-ийн оюутнуудын монгол хэлний хичээлийн жилийн эцсийн дүнгийн амжилт, чанарын ахиц

Хичээлийн жил	2021-2022	2022-2023	2023-2024	2024-2025
Амжилт	90.25	100	100	100
Чанар	50.06	61.13	63.09	64.48

8. Талархал

Тус өгүүллийн эрдэм шинжилгээний үнэ цэн, бичвэрийн шаардлагын тал дээр үнэтэй санал зөвлөгөө өгсөн доктор (Sc. D), профессор Г.Батзаяа Танд талархлаа илэрхийлье. Мөн судалгаанд оролцсон МКТК-ийн оюутнууд, хамтран ажилласан мэргэжил нэгт монгол хэл, бичиг, уран зохиолын багш Б.Удвал багшид талархал дэвшүүлье.

Товчилсон үг, тэмдэглэгээний тайлбар:

7-эгшигт гийгүүлэгч

9-заримдаг гийгүүлэгч

Э-эгшиг

Г-гийгүүлэгч

Ном зүй

А. Монгол хэлээр:

Боловсролын хүрээлэн. (2019). *Суралцахуйн удирдамж*. Улаанбаатар: Улаанбаатар принт. [Bolovsrolyn khureelen. *Suraltsakhuin udirdamj* [Study guide]. Ulaanbaatar: Ulaanbaatar print. 2019.]

Гэрэлмаа, Г., Дарьяа Бадмаева Гедеева. (2020). *Монгол хүний бичиг үсгийн чадварын судалгаа*. ОХУ. Халимагийн ШУ-ны төв: Монголоведение. Том 12, №4. [Gerelmaa, G; Darya Badmaeva Gedeeva. *Mongol khunii bichig usgiin chadvaryn sudalгаа* [A study of Mongolian literacy skills]. Russia: Khalimagiin shinjlekh ukhaany tuv. 2020]

Даваасүрэн, Н., Энхчимэг, Б. (2014). *Зөв бичихэд тань тусалъя*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Davaasuren, N., Enkhchimeg, B. *Zuv bichikhed tani tusalya* [Let us help you write correctly]. Ulaanbaatar: Soyombo printing LLC. 2014]

Хэлний Бодлогын Үндэсний Зөвлөл. (2018). *Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь /цахим хэлбэрээр/*. Улаанбаатар. [Khelnii bodlogyn undesnii zuvlul. Mongol khelnii zuv bichikh durmiin juramlasan toli [A dictionary of Mongolian spelling rules]. Ulaanbaatar: 2018]

Мөнгөнцэцэг, Б. (2017). Орчин цагийн монгол хэлний зөв бичих дүрмийн зарим асуудалд. *Монгол судлал сэтгүүл, 41-р боть*. (№483): 69-75. [Munguntsetseg, B. Some issues of modern Mongolian spelling rules. *Mongol sudlal setguul*, 2017, Vol 41. (№483): 69-75.]

Б. Гадаад хэлээр:

Luz Rello, Clara Bayarri, Yolanda Otal and Martin Pielot (2014) A Computer-Based Method to Improve the Spelling of Children with Dyslexia. pp. 153-160. <http://doi.org/10.1145/2661334.2661373>.